



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 4/327

Номгон

Газар эзэмших эрхийн гэрчилгээт
дуудлага худалдаа зарлах тухай

Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн "Улсын хэмжээнд 2026 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаал батлах" тухай 45 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын 1.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 10/73 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Баянхонгор сумын Номгон 1-р баг, Лувсанданзанжанцангийн өргөн чөлөө-5 гудамж 523а тоот хаягт байрлах Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай 420м² газрыг, Номгон 1-р Тээвэрчдийн гудамж-3 305а тоот хаягт байрлах Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газрын зориулалттай 2302м² газруудад хавсралтад заасны дагуу Газар эзэмших эрхийн гэрчилгээт дуудлага худалдааг зарласугай.

2. Дуудлага худалдаа зохион байгуулах газрын мэдээллийг хавсралтаар баталсугай.

3. Дуудлага худалдааг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Г.Энхбаяр), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны 05 дугаар сарын
29-ний өдрийн 4/327 дугаар захирамжийн
хавсралт



ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭТ ДУУДЛАГА
ХУДАЛДААГААР ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН ЖАГСААЛТ

№	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Баг	Байршил	Зориулалт	Талбайн хэмжээ /м2/	Анхны үнэ	Дэнчинги йн үнэ	Дуудлага худалдаа зохион байгуулагдах он.сар.өдөр
1	2	3	4	5	6	7	8	9
1	4956285	Номгон 1-р баг	Номгон 1-р гудамж Лувсанданзанжанца нгийн өргөн чөлөө-5 523а тоот	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай	420м ²	3 150 000	315000	2026.06.30
2	4971907	Номгон 1-р баг	Номгон 1-р гудамж Тээвэрчдийн гудамж- 3 305а тоот	Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газрын зориулалттай	1537м ²	3 688 800	368 880	2026.06.30

оОо



وکیل مسئولیت در حدیث در
در حدیث حدیث در حدیث

تاریخ: ۱۳۹۰/۰۶/۰۵
محل: تهران
موضوع: حدیث در حدیث

تاریخ: ۱۳۹۰/۰۶/۰۵

وکیل مسئولیت در حدیث در حدیث

تاریخ: ۱۳۹۰/۰۶/۰۵
محل: تهران
موضوع: حدیث در حدیث

وکیل مسئولیت در حدیث در حدیث

وکیل مسئولیت در حدیث در حدیث

وکیل مسئولیت در حدیث در حدیث



وکیل مسئولیت در حدیث در حدیث

626010673